**Ээлжит хичээлийн хөтөлбөр-1**

**Хамрах хүрээ: 9-р анги** **Хугацаа: 40мин**

**Сэдэв:** Тэгш хэмийн хувиргалт

**Зорилго:** Дүрсийг координатын тэнхлэгүүдийн хувьд тэгш хэмтэй хувиргаж, координатуудын хамаарлыг тодорхойлох

**Зорилт:**

- Хэрчмийн дундаж цэгийн координатыг олох
- Тэнхлэгийн болон төвийн тэгш хэмээр хувиргах
- Дүрс ба дүрийн координатуудын хамаарлыг тодорхойлох

**Агуулгын залгамж холбоо :**

| Өмнө судалсан агуулга | Цаашид судлах агуулга |
|---|---|
| - Эргүүлэлт, тэнхлэгийн тэгш хэм, параллель зөөлт, тэдгээрийн дараалсан хялбар хувиргалтуудаар хавтгайн дүрсүүдийг хувиргах<br>- Гомотеттэй холбоотой хэллэг, тэмдэглэгээг ойлгох, хэрэглэх, өгсөн цэгт төвтэй эерэг бүхэл тоон коэффициенттэй гомотетээр хувиргах | - Өгсөн коэффициенттэй гомотетоор хувиргах ($k>0$), эргүүлэлт, параллель зөөлтөөр хувиргах,<br>- Тэгш хэм (M), эргүүлэлт (R), параллель зөөлт (T), гомотет (E), тэдгээрийн нийлмэл хувилбарууд (хэрэв $M(a)=b$ ба $R(b)=c$ бол $R\cdot M(a)=c$ тэмдэглэгээг ашиглах.) |

**Цагийн төлөвлөлт:**

| Хичээлийн бүтцийн явц | Багшийн үйл ажиллагаа | Сурагчийн үйл ажиллагаа |
|---|---|---|
| Хичээл зохион байгуулалт - 1 минут | - Сурагчидтай мэндлэнэ<br>- Хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэнэ. Хичээлийн дэг, үнэлгээгээ танилцуулна | - Багштай мэндлэнэ<br>- Сурагчид хичээлийн бэлтгэл байдлыг хангана. |

| | | |
|---|---|---|
| Сэргээн санах (Сэдэлжүүлэлт)<br>5 минут | Дасгал: 1<br>A(2; 1); B(5;4); C(7;2) цэгүүдийг координатын хавтгайд байгуулж Ox,Oy тэнхлэгийн дагуу төвийн болон тэнхлэгийн тэгш хэмээр хувиргаарай.<br>Ox тэнхлэгийн хувьд тэгш хэмтэй хувиргасныг улаан өнгөөр, Oy тэнхлэгийн хувьд тэгш хэмтэй хувиргасныг ногоон өнгөөр, төвийн тэгш хэмээр хувиргасныг шар өнгөөр тус тус ялгаж тэмдэглэнэ үү? |  |

**Шинэ хичээл - 15 минут**

ABC гурвалжны дүрүүдийн оройн цэгийн координатыг дараах хүснэгтэнд бичнэ үү!

| ABC гурвалжин | Дүр1 (Ox) $A_1\ B_1\ C_1$ | Дүр 2(Oy) $A_2\ B_2\ C_2$ | Төвийн тэгш хэм $A_3\ B_3\ C_3$ |
|---|---|---|---|
| A(2,1) | _____ (2.-1) | ______( -2,1) | ______( -2,-1) |
| B(5,4) | _____( 5,-4) | ______( -5,4) | ______(-5, -4) |
| C(7,2) | _____( 7, -2) | ______( -7,2) | ______(-7, -2) |

- Дүрсийг Ox тэнхлэгийн хувьд тэгш хэмээр хувиргахад оройн цэгийн координатууд __________________ өөрчлөгдөж байна.
  (Oy тэнхлэгийн координат нь эсрэгээрээ, Ox тэнхлэгийн координат нь хэвээрээ байна.)
- Дүрсийг Oy тэнхлэгийн хувьд тэгш хэмээр хувиргахад оройн цэгийн координатууд __________________ өөрчлөгдөж байна.
  (Ox тэнхлэгийн координат нь эсрэгээрээ, Oy тэнхлэгийн координат нь хэвээрээ байна.)
- Дүрсийг Төвийн тэгш хэмээр хувиргахад оройн цэгийн координатууд __________________ өөрчлөгдөж байна.
  (Цэгүүд нь бүгд эсрэг тэмдэгтэй болж өөрчлөгдөж байна.)

**Бататгах - 10 минут**

**Дараах хувиргалтуудыг зөв харгалзуулна уу?**

1.Ox тэнхлэгийн тэгш хэм

2.Oy тэнхлэгийн тэгш хэм

3.Төвийн тэгш хэм

| | **Дүрс** | **Дүр** |
|---|---|---|
| **a** | (3, -1) . ( 2, 4), ( 6,-3) | (-3,-1), (-2,4), (-6,-3) |
| **b** | **(**3, -1) . ( 2, 4), ( 6,-3) | (-3,-1), (-2,-4),(6,-3) |
| **c** | (3, -1) . ( 2, 4), ( 6,-3) | (3,1), (2,-4), (6,3) |

Зөв хариулт 1c 2a 3b

| | | |
|---|---|---|
| Дүгнэлт<br>- 2 минут | Дүгнэлт асуулт<br>Төвийн болон тэнхлэгийн тэгш хэмээр хэрхэн хувиргасан бэ? | - Сурагчид хийж гүйцэтгэсэн даалгавар дээрээ тулгуурлан хариулах |
| Гэрийн даалгавар<br>- 2 минут | | |